

Сар тутмын мэдээллийн хуудас

УСНЫ КОМПАКТ

Гэр хорооллын төвийн шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг автоматжуулж, УСУГ-т хүлээлгэн өглөө



2025 оны 9 дүгээр сарын 23



90%
УЛААНБААТАР ХОТЫН НИЙТ УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

94% ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

91% ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

85% ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр орчимд 188 бодгаль тарвага бүртгэгджээ

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр орчмын нутаг дэвсгэрт Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны шалгуураар адил “устаж болзошгүй” ангилалд бүртгэгдээд буй Монгол тарвага оршин амьдардаг тул Монголын Мянганы сорилтын сангаас тухайн төсөл хэрэгжүүлэх газрын биологийн олон янз байдлын чухал төлөөлөл зүйл болгон анхаарал хандуулж, түүний амьдрах орчныг тэтгэх, төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 11 дүгээр сард боловсруулж, түүнд тусгагдсан үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсээр байна.

Үргэлжлэл 8-р нүүрт

Тоон мэдээ:

Бүтээн байгуулалт эхэлснээс хойш:

- 7929** Хүнийг ажлын байраар хангасан
- 92%** Монголчууд
- 877** Эмэгтэй /11%/
- 36%** СХД, ХУД, БГД-ийн иргэд
- 79.2** ЖДҮ-ээс худалдан авсан бараа үйлчилгээ (тэрбум.төг)





ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим шоо метрээр нэмэгдэх юм.

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын нийт гүйцэтгэл 99.84%-д хүрээд байна




Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажил дуусч, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны туршилт тохируулгын ажил үргэлжилж байна.

2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар

- 99.96%** Үйлдвэрийн гадна талбайн ажил
- 100%** Ус гүн цэвэршүүлэх байгууламжийн барилга
- 100%** Цэвэршүүлсэн усны сан болон насос станцын барилга
- 100%** Урвуу осмосын байгууламжийн барилга
- 100%** Тунадас боловсруулах байгууламжийн барилга
- 100%** Цахилгаан/генераторын барилга
- 100%** Харуулын барилга

Цахилгааны инженер, техникийн ажилтнуудад практик сургалт зохион байгууллаа



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 677 дугаар тогтоолоор Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн 10кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийн ашиглагч байгууллагаар Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ (УБЦТС) ТӨХК-ийг тогтоосны дагуу ашиглагч байгууллагад шилжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд

үйлдвэр дээр 3 өдрийн танхимын болон практик сургалтыг “УБЦТС” ТӨХК-ийн инженер, техникийн ажилтнуудад зохион байгууллаа. Тус сургалтын үеэр 10кВ-ын ХХБ, 10/0.4кВ трансформаторууд /КТПН/, СКАДА системийн танилцуулга, аюулгүй ажиллагааны зааварчилгаа зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

“Баран групп”-ийн гүйцэтгэж буй нийт ажлын гүйцэтгэл 83.65%-тай байна



- 78.6%** Биокомбинатын эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил
- 58.4%** Шувуун эх үүсвэрийн гүний худгийн барилгын ажил
- 99.2%** Шувуун дамжуулах шугам хоолойн болон хаалтын худаг
- 64.6%** Төслийн нийт сүвлэгээний ажил
- 73.5%** Шилэн кабель



ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр (“ХУДБУ”) болон дахин боловсруулсан усыг “ДЦС-3”, “ДЦС-4” ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжсэнээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.

Дипломат төлөөлөгчид Хаягдал ус дахин боловсруулах төслийн ажилтай танилцлаа

АНУ-ын МСК-ын суурин төлөөлөгч Тина Юүгийн урилгаар Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчид болон олон улсын байгууллагуудын төлөөлөл шинэ Төв цэвэрлэх байгууламж болон Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр танилцлаа.



Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 95.6%



Дахин боловсруулсан усны ашиглалт, үнэ тарифын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээг эхлүүлээ



Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд Дахин боловсруулсан усны ашиглалт, үнэ тарифын эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт зохицуулалтыг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг 2025 оны 5-9 дүгээр сард амжилттай зохион байгууллаа. Монголын Мянганы сорилтын сан тус тендерт шалгарсан Францын “Espelia”, “Seureca” болон Монголын “Еврохан” компаниудын түншлэлтэй 2025 оны 9 дүгээр сарын 1-нд зөвлөх үйлчилгээний гэрээнд гарын үсэг зурав.

Уг зөвлөх үйлчилгээг эхлүүлэх уулзалт 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр боллоо. Уулзалтад Монголын МСС, холбогдох яам, агентлаг, мэргэжилтнүүдийн төлөөлөл оролцож, хууль эрх зүйн сорилт, тарифын асуудлаар санал солилцов.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг хэвийн ажиллуулж, үр дүнтэй ашиглахын тулд дахин боловсруулсан усны ашиглалт, үнэ тариф болон түүнийг зохицуулах хууль эрх зүйн орчныг тодорхой болгох нь чухал. Усны Компакт хэрэгжиж дуусахад буюу Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийг Засгийн газар, УСУГ-т хүлээлгэж өгөх үед хууль эрх зүйн зохицуулалт нь тодорхой болсон байх шаардлагатай.

Зөвлөх баг гурван чиглэлээр зэрэг ажиллаж, оролцогч талуудын үүрэг, оролцоог тодорхой болгон, богино хугацаанд ажлыг үр дүнтэй гүйцэтгэхээр төлөвлөж байна.

100%	Хаягдал ус хүлээн авах худгийн барилга
99%	Шахуургын станц №1
97%	Тогтворжуулах сан
98.5%	Хөдөлгөөнт био реакторын байгууламж
98.3%	Ламелла тунгаагуурын байгууламж
94.8%	Ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилга
96.7%	Халдваргүйжүүлэх сан
91.5%	Шахуургын станц №2
98%	Ус зайлуулах сангийн барилга
89%	Хлор бэлтгэлийн барилга

Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС-уудын өөрчлөлтийн ажлын явц 84.7%-тай байна



Өргөлтийн насос станцаас “ДЦС-3” ТӨХК хүртэлх 500м голчтой 2 км шугам хоолойг угсарч суурилуулсан бөгөөд гүйцэтгэл 96.9%-тай байна.

- Салаалах худгаас өргөлтийн насос станц хүртэлх 700мм голчтой шугам хоолойн ажлын гүйцэтгэл 83.8%-тай үргэлжилж байна.
- “ДЦС-3” ТӨХК-ийн өөрчлөлтийн ажлын гүйцэтгэл 89.3% байгаа бөгөөд ус дамжуулах системийн хяналтын СКАДА системийн суурилуулалтын ажил үргэлжилж байна.
- Ус дамжуулах шугам хоолойн удирдлагын СКАДА системийн угсралт суурилуулалтын ажлын гүйцэтгэл 34% байна.

Товчхон

Үйлдвэрийн гадна 10кВ хаалттай дэд өртөө, 2.2 км цахилгааны шугам сүлжээний ажлын барилга угсралт ба тест тохируулгын ажлыг гүйцэтгэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын шийдвэрийн дагуу ашиглалтад оруулсан.



Захиргааны барилгыг ашиглалтад оруулах хүсэлт илгээсэн бөгөөд улсын комисс томилох шийдвэрийг хүлээж байна.



ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Гэр хорооллын 180 ус түгээх байрыг автоматжуулж, УСУГ-т хүлээлгэн өглөө



Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн Гэр хорооллын ус хангамжийн үйлчилгээний зардлыг бууруулах дэд үйл ажиллагааны хүрээнд гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг бүрэн автоматжуулж, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар (УСУГ)-т 2025 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр албан ёсоор хүлээлгэн өглөө.

Ёслолын ажиллагаа Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хорооны 207 дугаар ус түгээх байрны гадна талбайд болж, УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга, УИХ дахь Монгол-Америкийн парламентын бүлгийн дарга Х.Ганхуяг, УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ричард Буанган, АНУ-ын Мянганы сорилтын

корпорац, ХББОСЯ, ХСУХАТАУЗХ, УСУГ, Монголын Мянганы сорилтын сан, тус хөтөлбөрийн хяналтын зөвлөх “Тетра Тех” компани, гүйцэтгэгч “Эйч Ти Эл” ХХК зэрэг байгууллагын төлөөлөл оролцов.

Гэр хорооллын ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлж, УСУГ-ын үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилготойгоор 2023 оны 1 дүгээр сараас 2025 оны 8 дугаар сарыг дуустал хэрэгжсэн уг төслийн хүрээнд нийслэлийн зургаан дүүргийн 61 хороонд байрлах 180 ус түгээх байрны цахилгаан, узель, тоног төхөөрөмж, өнгөлгөө засал, аюулгүй ажиллагааны системийг иж бүрнээр шинэчилж, ухаалаг төхөөрөмжөөр тоноглон автоматжууллаа.

Мөн өмнө нь автоматжуулсан 151 ус түгээх байрыг нэгтгэн, нийт 331 ус түгээх байрны үйл ажиллагааг хянах

нэгдсэн хяналт, удирдлагын системийг амжилттай нэвтрүүлсэн юм.

Төслийн үр дүнд нийслэлийн гэр хорооллын 100,000 орчим иргэн ус түгээх байраар цагийн хязгаарлалтгүйгээр үйлчлүүлэх боломжтой болохын зэрэгцээ ухаалаг төхөөрөмжөөр дамжуулан усны картаар болон төлбөрийн олон төрлийн цахим хэрэгсэл ашиглан усаа авах, цаашлаад усны хэрэглээгээ хянах нөхцөл бүрдлээ.

Шинэчлэгдсэн 180 ус түгээх байрны 21 нь ачилтын ус түгээх байр бөгөөд ачилтын ус түгээх байруудыг автоматжуулснаар УСУГ-ын зөврийн 370 гаруй ус түгээх байрыг усаар хангадаг 60 орчим усны машин болон Онцгой байдлын ерөнхий газрын Гал унтраах, аврах ангийн машинууд усаа ямар ч цагт саадгүй авах боломжтой болсон нь чухал ач холбогдолтой юм.

Нийслэлийн зургаан дүүргийн гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг 24/7 ажиллагаатай болгож, бүрэн автоматжуулав.

АВТОМАТ УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД АНГИУДЫН ОНЦЛОГ

- Даварын засварын ажил
- Дотор хөвөн засварын ажил
- Датан ногтол
- Супер усны IPE7 стандартад нийцсэн цахилгаан сансар
- Цахилгаан тогтворжуулагч (UPS)
- Программ кодланг олголт
- Программ кодланг олголт
- Хөвөн дамжуулагч бүрэн автомат
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Зөвхөндгүүг Гаг үнэний, холбоо хяналт

Нийт 331 Ухаалаг ус түгээх байр нэгдсэн нэг системээр 24 цагийн турш Улаанбаатар нэгдсэн удирдлага хяналтын систем

УСНУУНГАМЖИЙН ШИНЭЧЛЭЛ

- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл

САЙТЫН ШИНЭЧЛЭЛ

- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл

ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН БҮРЭН ШИНЭЧЛЭЛ

- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл

АВТОМАТЖУУЛАЛТЫН АЖИЛ

- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл

СИСТЕМЫН ШИНЭЧЛЭЛТ

- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл
- Усны хэрэглээг багасгах
- Усны үнэний системийг өндөрсөн үед усны зардалтай харьцуулж тэнцүүл



АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд **Ричард Буанган:**



“Аюулгүй, найдвартай ундны усаар хангагдах нь өрх бүрийн өдөр тутмын амин чухал хэрэгцээ, хөрөнгө оруулалтыг ч хөтөлдөг хүчин зүйл. Улаанбаатарчуудыг цэвэр усаар тогтвортой хангах боломжтой болсноор хувийн хэвшил, бизнесүүд тэлэх, цаашлаад нийслэл хотын эдийн засаг урт хугацаанд өсөж хөгжих бат бөх суурийг тавьж байна”.

УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга, УИХ дахь Монгол-Америкийн парламентын бүлгийн дарга **Х.Ганхуяг:**

“Ухаалаг худагтай болсноор иргэд хүссэн цагтаа усаа авах боломжтой болохын зэрэгцээ иргэдэд усны үйлчилгээг хүргэх УСУГ-ын үйл ажиллагааны зардлыг мөн хэмнэж байгаа нь Усны Комплектын төсөл, хөтөлбөрүүд улаанбаатарчуудын өдөр тутмын амьдралд бодит үр өгөөжөө өгч эхэлсний нэгэн тод жишээ юм”.



УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга **Д.Цогтбаатар:**



“Цаасан дээр үзэглэж байсан Компакт гэрээний төсөл, хөтөлбөрүүд хөрсөн дээр бууж, эхнээс нь албан ёсоор хүлээлгэн өгч байгаад баяртай байна. Усны Компакт нь усны салбарт тулгамдсан асуудлуудыг үр дүнтэйгээр шийдвэрлэхийн тулд бүх талын нөхцөлийг судалж, зохих арга хэмжээг тусгасан цогц хөтөлбөр болж чадсан. Энэхүү төсөл ирээдүйд хамтын хүчээр Улаанбаатар хотын усны асуудлыг цогцоор нь шийдвэрлэх бат бөх суурь болно гэдэгт итгэлтэй байна”.

Сонгинохайрхан дүүргийн 2 дугаар хорооны иргэн **Л.Сугаржав:**

“АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн санхүүжилтээр хийсэн автоматжуулсан энэ худаг ард түмэн бидэнд маш хэрэгтэй. Өмнө нь ажилтай, ажилгүй үе таарна, амралттай, цаг болоогүй, эсвэл хаасан гээд авч чадахгүй хүн зөндөө байсан. Одоо бол өглөө, орой хэдийд ч очоод картаа уншуулаад авах боломжтой болсон. Амьдралд ойр, ажилтай хүмүүсийн цаг завьг хэмнэсэн ийм сайхан ажил хийж өгсөн Америкийн ард түмэнд баярлалаа.”



ВЭЛГЭХ КӨННӨХ





ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.



Усны лабораторийн ажилтнууд Нидерланд улсад олон улсын туршлага судаллаа

Ус ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөр (WOP)-ийн хүрээнд Нидерланд улсад зохион байгуулсан 9 дэх удаагийн сургалт, туршлага судлах аялалд усны салбарын лабораторийн 14 ажилтан 2025 оны 9 дүгээр сарын 13-21-нд оролцлоо. Энэ удаагийн сургалтын агуулга лабораторийн дотоод үйл ажиллагаанд төвлөрсөн бөгөөд Нидерландын усны тэргүүлэх дөрвөн лабораторид (Laboratorium, Viten Leeuwarden, Water Lab Noord, LeAF) зохион байгуулав.

Энэхүү хөтөлбөр нь Усны Компактын хүрээнд УСУГ-т нийлүүлж буй орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмжийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой юм.

Усны үйлчилгээ болон нийгмийн хамгааллын салбарын төлөөллүүд уулзаж санал солилцлоо

Усны төлбөр төлөх чадварын асуудлыг салбар дундын бодлого хөтөлбөрөөр хэрхэн шийдвэрлэх талаар усны үйлчилгээний болон нийгмийн хамгааллын салбарын төлөөллүүд 9 дүгээр сарын 25-нд болсон Хэрэглэгчдийн татаас болон хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн хувилбаруудыг танилцуулах уулзалтын үеэр ярилцаж, санал солилцлоо. Бага орлоготой өрхүүд рүү чиглэсэн бодлого, хөтөлбөрийн төслийг “Ди Эйч Инфрастратчар” ХХК, ААРК ХХК-ийн түншлэл боловсруулж, уг хэлэлцүүлгийн үеэр танилцуулсан юм.

Хэлэлцүүлгийн төгсгөлд МСК-ын Нийгмийн дүн шинжилгээ хариуцсан захирал Шэрон Рожерс:

“Нэг талаасаа зөвхөн бага орлоготой хэрэглэгчдийг дэмжиж, нөгөө талаас төлбөрийн чадвартай өрхийн усны үйлчилгээний үнийг нэмснээр Улаанбаатар хотод усны үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд өртгөө нөхөж, чанараа сайжруулан ажиллах боломж бүрдэх юм. Хэдийгээр Улаанбаатар хотын усны үйлчилгээний салбар нь олон лиценз эзэмшигчтэй, тархай бутархай зохицуулахад хүндрэлтэй ч, Монголын Усны Компактаар



дамжуулан энэ асуудалд шийдэл гаргаж байгаа нь алдаж болохгүй боломж хэмээн харж байна.”

Хэрэглэгчийн мэдээллийн сангийн цахим системийн Бета хувилбарыг танилцуулав

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын Хэрэглэгчийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, системийн хөгжүүлэлтийн Бета хувилбарыг танилцуулах уулзалтыг 2025 оны 9 дүгээр сарын 9-нд зохион байгууллаа.

Хэрэглэгчийн мэдээллийн сангийн цахим систем нь Ус хангамж, ариутгах татуургын хэрэглэгчийн үйлчилгээг цахимжуулах зорилгоор хөгжүүлж буй Хэрэглэгчийн үйлчилгээний дижитал платформ (Хэрэглэгчийн төлбөр тооцооны систем, Хэрэглэгчийн портал систем, хэрэглэгчийн дуудлага санал гомдлын бүртгэл, хяналтын систем) -ын суурь бааз юм.


Уулзалтад Усны үйлчилгээг зохицуулах хороо болон ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөл оролцож, системийн демо хувилбартай танилцан мэдээлэл оруулах практик чадварт суралцлаа.



БАЙГАЛЬ ОРЧИН - НӨХӨН СЭРГЭЭЛТ

Барилга угсралтын ажлын төлөвлөлт, биелэлтийн бүхий л шатанд байгаль орчныг хамгаалахтай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль эрх зүйн орчин, Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандартад нийцүүлэн ажилладаг.

Усны Комплектын хүрээнд 11,400 мод, бут тарьж, ургуулан Нийслэлийн Байгаль орчны газарт хүлээлгэн өглөө



Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн талбай дахь түүхий ус цуглуулах, дамжуулах шугам хоолой суурилуулахад барилга угсралтын ажлын газар чөлөөлөлтөд 55 км зурвас буюу голын дагуу нийт 1000 орчим ширхэг байгалийн бургас, хайлаас шууд нөлөөлөлд өртсөнийг хууль тогтоомжийн дагуу нөхөн тарьсан. Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт Шувуун фабрик орчмын

газрын доорх усны ус хуримтлуулах талбайн 5.3 га газарт татмын ойн зурвас байгуулж, экосистемийн үйлчилгээг тэтгэх зорилгоор 10 мянган ширхэг бургас, улиас, хайлаас тарьж, ургуулан 2025 оны 10 дугаар сарын 3-нд Нийслэлийн ногоон бүсийн ойн санд хүлээлгэн өглөө. Мөн Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд ДЦС-3, ДЦС-4 рүү дахин боловсруулсан ус дамжуулах

шугам хоолой, ДЦС-уудын өөрчлөлтийн барилга угсралтын ажлын нөлөөлөлд өртөж буй 140 орчим бургас модыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 1400 бургас модыг Улаанбаатар хотын Үйлдвэрийн ундны усны эх үүсвэрийн талбайд тарьсныг Нийслэлийн Байгаль орчны газарт 2025 оны 10 дугаар сарын 3-нд мөн хүлээлгэн өглөө.

Сонгинохайрхан дүүрэгт Хэлмэгдэгсдийн хөшөө орчмыг тохижууллаа

Ус хангамжийн Баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төслийн хүрээнд төслийн гүйцэтгэгч “Баран групп” ХХК нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт орших Хэлмэгдэгсдийн хөшөө орчмын тохижилтын ажлыг батлагдсан зураг, төслийн дагуу бүрэн гүйцэтгэлээ.



- Гурван шатлал бүхий автомашины зогсоол
- Сүүдрэвч, сандал болон явган хүний зам
- Орчны зүлэгжүүлэлт, мод тарих ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ийнхүү уг тохижилтын ажлын үр дүнд Хэлмэгдэгсдийн хөшөөний орчимд иргэдэд зориулсан ая тухтай шинэ орчин бүрдлээ.



ТАНИН МЭДЭХҮЙ

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр орчимд 188 бодгаль тарвага бүртгэгджээ

Түрүүч нь 1-р нүүрт

2025 оны зуны улиралд хийсэн найман удаагийн тооллогоос тухайн дош бүлээс хамгийн олон бодгаль ажиглагдсан тоон үзүүлэлт дээр үндэслэн тооцож үзэхэд гурван аманд нийт 188 бодгаль бүртгэгдсэн байна. Зуны улирал дахь насны бүтцийг үзэхэд, бүдүүн бодгаль 91, хотил буюу залуу бодгаль 49, мөндөл 48 толгой тус тус бүрдүүлж байв.

Монгол тарвага тус орны өндөр уулс, бэсрэг уулс, ухаа гүвээт талд илэрдэг хээрийн экосистемийн элдэв хэв шинж бүхий нутагт идээшин тархан амьдардаг. Энэ зүйл тарваганы нүхэнд хээрийн экосистемд зэрэгцэн оршдог гүрвэл, могой зэрэг хэвлээр явагч, мөн хярс, зараа, элдэв үе хөлт, нугаламгүй амьтад шүтэн амьдардаг. Иймд Монгол тарвагыг экосистемийн инженер, экосистемийг тэтгэх үйлчилгээ үзүүлдэг зүйл хэмээн судлаачид онцлон тэмдэглэдэг.



Чулуун далан, тогоо байгуулах замаар уруйн ганганы усны эвдрэлийг хязгаарлаж, хөвөө газар харгана оролцсон бүлгэмдэлд тарвага сорчлон иддэг ургамлын ургац нэмэгдсэн нь тэдэнд таатай нөхцөл бүрдүүлжээ.



Төв амны тарваганы дош руу хярс ойртох үед бүдүүн тарвага хярсгй хөөв.



Энэ намар хангалттай тарга тэвээрэг, өөх хуримтлуулж амжаагүй мөндөл, залуу тарвага 10 дугаар сар гартал идэвхтэй идээшилж байв.



Төв амны судалгааны талбайд оршдог хайлааст сайр жалгын хөвөө дагуу монгол чичүүлийн үлийн тархац хумигдав.



МОНГОЛД НЭВТРҮҮЛЖ БҮЙ ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИУД



Монголд анхны Ус гүн цэвэршүүлэх болон Хаягдал ус дахин боловсруулах томоохон үйлдвэр байгуулж байна.



Тусгай хөндлөн өрөмдлөгийн машин ашиглан авто зам, гол, төмөр зам доогуур сүвлэж, шугам хоолой тавьж байна. Монгол Улсад анх удаа 1000 мм голчтой шугам хоолойг автозамын хөдөлгөөнийг хаахгүйгээр зам доогуур сүвлэж тавьсан.



Урвуу осмосын дэвшилтэт технологиор усыг хамгийн нарийн түвшинд шүүнэ.



Гүний худгуудын тоноглолд хайрган шүүрийн оронд "glass beads" буюу шилэн бөмбөлгөн шүүр ашиглаж байна.



Шугам хоолойд 100 жилийн эдэлгээтэй, ундны ус дамжуулах зориулалттай зөөлөн ширмэн хоолой (ductile iron pipe) ашиглаж байна.



Монгол Улсын хэмжээнд хамгийн томд тооцогдох, ундны 18 мянган шоо метр ус хадгалах, газар доорх усан сан байгуулсан.



Гүний худгийн насосууд Монгол Улсдаа анхны хамгийн өндөр буюу секундэд 72-74 литр сорох хүчин чадалтай.